

“Кредит монгол ББСБ” ХХК-д итгэлцэл, цахим
төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх
нэмэлт тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 4.2, 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.”Кредит монгол ББСБ” ХХК-д итгэлцлийн үйлчилгээ болон цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх нэмэлт тусгай зөвшөөрөл олгосугай.

2.Улсын бүртгэлийн гэрчилгээнд холбогдох өөрчлөлтийг оруулж, 2008 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор гэрчилгээний хуулбарыг Хороонд ирүүлэхийг “Кредит монгол ББСБ” ХХК /Л.Цэрэндорж/-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ